

**ТОГТООЛД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7.1.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Сайжруулсан шахмал түлшний талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн 200 дугаар тогтоолын 1 дэх заалтын "2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд" гэсний дараа , 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 2022 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд 50 хувиар хөнгөлөх арга хэмжээг тус тус авч" гэж нэмсүгэй.
2. "Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоолын 1 дэх заалтын "7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл" гэснийг "12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал" гэж өөрчилсүгэй.
3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоолын 6 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

САНГИЙН САЙД Б.ЖАВХЛАН